

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/31/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 261885 Цахим хаяг: Erdenetsetsega@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Лхагвацэнд Утас: 261628 Цахим хаяг: Lkhagvatsendb@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Платиниум прогресс аудит ХХК-ий захирал Ж.Баяртуул Утас: 99066015 Цахим хаяг: platinumprogressaudit@gmail.com
-----------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


## **АГУУЛГА**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	4
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	7
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	14
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	19
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	19
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	20
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	21
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	21
<b>4.5. Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	21
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	22
<b>5.1 ТӨЛБӨРИЙН АКТ</b> .....	22
<b>5.2 АЛБАН ШААРДЛАГА</b> .....	22
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	25

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НХАТ	Нийслэл хотын албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 <b>ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР</b> Засгийн газрын IV байр, Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160 Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30, Цахим шуудан: info@audit.gov.mn, Цахим хуудас: www.audit.mn	<b>ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Г.ЧИНЗОРИГ ТАНАА</b>
<u>2026.08.16</u> № <u>06/632</u> танай _____-ны № _____-т	
<b>Хязгаарлалттай дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.</p> <p>Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.</p>	
<b>Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 178.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"><li>• Тайлант онд “автомашин дугуй худалдан авах” нээлттэй тендер зарлаж 2 нийлүүлэгчээс 103.1 сая төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 44.9 сая төгрөгийн дугуй худалдан авсан ба тендерт шалгараагүй компаниудаас нийт 70.3 сая төгрөгөөр 83 ширхэг дугуй худалдан авсан;</li><li>• Тайлант онд өргөдлийн дагуу 14 ажилтанд бусад зардлын данснаас 44.0 сая төгрөгийн зээл олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан бөгөөд оны эцэст 12.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн;</li><li>• Зөрчил гаргасан жолооч нарын 25 удаагийн торгуульд 6.8 сая төгрөгийг төлж, зардлаар тайлагнасан;</li><li>• Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 184 дүгээр тогтоолоор олгосон 15.0 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг бусад зардлаас гаргаж, цалингийн суутган тооцоолол хийлгүй гарт олгосон.</li></ul>	
<small>Z:\Yawsan_Bichig\2026\0316 SA/G-36.Docx</small>	
<b>1526141098</b>	

Дээрх зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1, 48.2.7 заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын “нийцсэн ба зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд нийт орлогыг 10,534.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 10,522.4 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 1,485.5 сая төгрөгөөр, 11.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлээр 8,314.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 9,407.8 сая төгрөгийн зардал гарган, 1,092.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд УИХ-ын Тамгын газар “автомашин худалдан авах эрх”-ээ тус байгууллагад шилжүүлсний дагуу тус баазад 2,991.5 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 17 тээврийн хэрэгслийг худалдан авч парк шинэчлэлт хийсэн байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Төрийн аудитын байгууллага нь шалгагдагч байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.3 хувьтай хэрэгжүүлсэн байна.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,806,837,068.45	156,159,588.46
1.1.02	Дансны авлага	194,823,554.75	363,029,504.39
1.1.04	Бусад авлага	7,821,616.98	24,768,916.98
1.1.06	Бараа материал	75,767,729.89	105,556,766.72
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10,507,307.79	15,246,896.77
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,095,757,277.86</b>	<b>664,761,673.32</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	13,519,719,544.98	14,810,564,640.68
1.2.02	Биет бус хөрөнгө	725,983,222.28	783,264,889.04
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,245,702,767.26	15,593,829,529.72
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,341,460,045.12</b>	<b>16,258,591,203.04</b>
2.1.1.01	Дансны өглөг	-	565,174,132.50
2.1.1.03	Татварын өр	265,227,373.16	482,656,507.50
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	198,237,890.66
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	713,883,460.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	237,293,738.54	207,675,592.54
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	16,681,166.00	53,502,922.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>519,202,277.70</b>	<b>2,221,130,505.20</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>519,202,277.70</b>	<b>2,221,130,505.20</b>
2.3.01	Өмч: - төрийн	11,744,520,814.45	11,744,520,814.45
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,122,044,177.04	2,144,044,177.04
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	718,836,000.00	718,836,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,236,856,775.93	(569,940,293.65)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(1,092,913,609.58)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,236,856,775.93	522,973,315.93
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>15,822,257,767.42</b>	<b>14,037,460,697.84</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,341,460,045.12</b>	<b>16,258,591,203.04</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	12,270,919,192.56	7,416,510,956.90
02	Борлуулалтын өртөг	10,704,931,390.44	7,914,238,029.26
<b>03</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>1,565,987,802.12</b>	<b>(497,727,072.36)</b>
04	Түрээсийн орлого	445,802,499.98	405,138,909.08
05	Хүүний орлого	-	-
06	Ногдол ашгийн орлого	-	-
07	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
08	Бусад орлого	323,194,922.88	493,244,466.11
08.1	Орлогын дүн	768,997,422.86	898,383,375.19
09	Борлуулалт, маркетингийн зардал	613,636.36	9,445,922.73
10	Ерөнхий ба удирдлагын зардал	515,317,100.31	711,344,928.25
11	Санхүүгийн зардал	805,182.81	1,536,171.61
12	Бусад зардал	211,273,030.02	114,262,581.82
12.1	Зардлын дүн	728,008,949.50	836,589,604.41
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(112,966,509.39)	(656,980,308.00)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	-
17.1	Олз, гарзын дүн	(112,966,509.39)	(656,980,308.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)	1,494,009,766.09	(1,092,913,609.58)
19	Орлогын татварын зардал	66,242,847.80	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,427,766,918.29	(1,092,913,609.58)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	1,427,766,918.29	(1,092,913,609.58)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>01</b>	<b>2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>11,744,520,814.45</b>	<b>2,112,044,177.04</b>	<b>718,836,000.00</b>	<b>(190,910,142.36)</b>	<b>14,384,490,849.13</b>
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
<b>03</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-	-	-	-
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,427,766,918.29	1,427,766,918.29
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	10,000,000.00	-	-	10,000,000.00
<b>09</b>	<b>2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл</b>	<b>11,744,520,814.45</b>	<b>2,122,044,177.04</b>	<b>718,836,000.00</b>	<b>1,236,856,775.93</b>	<b>15,822,257,767.42</b>
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
<b>11</b>	<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,092,913,609.58)	(1,092,913,609.58)
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	(713,883,460.00)	(713,883,460.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	22,000,000.00	-	-	22,000,000.00
<b>17</b>	<b>2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл</b>	<b>11,744,520,814.45</b>	<b>2,144,044,177.04</b>	<b>718,836,000.00</b>	<b>(569,940,293.65)</b>	<b>14,037,460,697.84</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>14,062,506,406.49</b>	<b>8,433,403,015.68</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	10,896,571,480.00	4,508,962,023.00
1.1.10	Техникийн хяналтын орлого	-	12,242,018.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	16,733,963.00	42,526,131.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,968,000,000.00	2,653,500,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	185,557,898.49	29,739,216.68
1.1.7	Түрээсийн орлого	486,810,650.00	445,554,800.00
1.1.8	Гаражийн түрээсийн орлого	508,832,415.00	627,536,890.00
1.1.9	Ашиглалтын төлбөрийн орлого	-	113,341,937.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>10,588,432,093.75</b>	<b>6,997,771,871.20</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,678,673,250.99	3,601,409,027.23
1.2.10	Шуудан холбоо суваг ашиглалтад төлсөн	18,981,655.06	10,310,096.56
1.2.11	Харуул хамгаалалтад төлсөн	181,610,000.00	116,245,993.00
1.2.12	Ажилчдад олгосон тэтгэмж	84,821,048.00	18,300,000.00
1.2.13	Албан томиллогод төлсөн	300,625,508.00	317,959,933.00
1.2.14	Сэлбэг хэрэгсэлд төлсөн	428,666,650.00	423,192,995.00
1.2.15	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	2,105,231,261.00	133,593,610.00
1.2.16	Баяр ёслолын зардалд төлсөн	-	-
1.2.17	Сургалтын зардалд төлсөн	1,739,000.00	-
1.2.18	Урсгал засварын зардал	143,717,370.00	25,153,000.00
1.2.19	Аж ахуйн зардал	7,529,960.00	32,385,842.00
<b>1.2.2</b>	<b>Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн</b>	<b>459,911,944.90</b>	<b>358,062,152.98</b>
1.2.20	Хөдөлмөр хамгаалалын зардалд төлсөн	14,636,900.00	7,138,100.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	36,228,806.00	79,410,625.80
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	207,949,118.15	254,087,114.79
1.2.5	Түлш шатахуун, тос маслод төлсөн	2,202,942,895.00	1,261,133,331.57
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	661,012.86	756,745.41
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	350,517,960.25	122,091,618.33
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	69,403,456.00	60,202,966.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	294,584,297.54	176,338,719.53
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,474,074,312.74	1,435,631,144.48
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,332,991.48	7,641,843.03
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	20,000.00	25,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	11,256,983.88	7,616,843.03

“Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.1.8	Бусад	56,007.60	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>2,362,552,067.00</b>	<b>3,093,950,467.50</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,640,075,400.00	2,667,552,132.50
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,775,000.00	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	717,701,667.00	426,398,335.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,351,219,075.52)	(3,086,308,624.47)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,122,855,237.22</b>	<b>(1,650,677,479.99)</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,190,728,224.29	1,806,837,068.45
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,806,837,068.45	156,159,588.46

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэтгэл	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>			<b>13,039,916.6</b>	<b>10,534,063.1</b>	<b>8,314,894.3</b>	<b>4,725,022.3</b>	<b>63.8</b>	<b>2,219,168.8</b>	<b>78.9</b>
1	Тээврийн орлого	м.төг	9,833,710.6	6,228,118.2	4,337,568.8	5,496,141.8	44.1	1,890,549.4	69.6
	Түрээсийн орлого	м.төг	915,011.1	893,954.9	988,190.4	(73,179.3)	108.0	(94,235.5)	110.5
	Хөрөнгө оруулалтын орлого	м.төг	1,968,000.0	2,000,000.0	2,481,476.8	(513,476.8)	126.1	(481,476.8)	124.1
	ТХХ үзлэгийн орлого	м.төг	-	911,990.0	12,902.7	(12,902.7)		899,087.3	1.4
	Бусад орлого	м.төг	323,194.9	500,000.0	494,755.7	(171,560.7)	153.1	5,244.3	99.0
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>13,039,916.6</b>	<b>10,534,063.1</b>	<b>8,314,894.3</b>	<b>4,725,022.3</b>	<b>63.8</b>	<b>2,219,168.8</b>	<b>78.9</b>
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>11,545,906.9</b>	<b>9,497,802.2</b>	<b>9,407,807.9</b>	<b>2,138,099.0</b>	<b>81.5</b>	<b>89,994.3</b>	<b>99.1</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	515,930.7	736,587.5	720,790.9	(204,860.2)	139.7	15,796.6	97.9
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>1,494,009.7</b>	<b>1,036,260.9</b>	<b>(1,092,913.6)</b>	<b>2,586,923.3</b>	<b>(73.2)</b>	<b>2,129,174.5</b>	<b>(105.5)</b>
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>1,427,766.9</b>	<b>11,690.3</b>	<b>-</b>	<b>1,427,766.9</b>	<b>-</b>	<b>11,690.3</b>	<b>-</b>
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>1,846,250.1</b>	<b>2,134,380.2</b>	<b>1,293,045.9</b>	<b>553,204.1</b>	<b>70.0</b>	<b>841,334.2</b>	<b>60.6</b>
	а/ Орлогын татварт	м.төг	66,242.9	1,169.0	25,295.9	40,946.9	38.2	(24,126.9)	2,163.8
	б/ НӨТ	м.төг	912,837.0	730,369.4	545,634.9	367,202.1	59.8	184,734.5	74.7
	в/ НДШ	м.төг	459,823.9	636,392.1	358,062.2	101,761.8	77.9	278,330.0	56.3
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	301,036.7	594,573.6	232,816.3	68,220.4	77.3	361,757.3	39.2
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	4,254.2	4,254.2	4,254.2	-	100.0	-	100.0
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	97,397.0	162,963.4	122,324.0	(24,927.0)	125.6	40,639.4	75.1
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	4,658.4	4,658.4	4,658.4	-	100.0	-	100.0

“Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг				-		-	
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	145.0	158.0	145.0	-	100.0	13.0	91.8
9	Нийт цалингийн сан	м.төг	3,760,245.1	5,091,136.8	3,785,728.8	(25,483.7)	100.7	1,305,408.0	74.4
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	2,161.1	2,685.2	2,175.7	(14.6)	100.7	509.5	81.0
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.9	1.0	1.2	(0.3)	130.3	(0.2)	116.0
12	Хөрөнгө оруулалт	м.төг	727,777.1	1,485,500.0	426,398.3	301,378.7	58.6	1,059,101.7	28.7
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>212,152.5</b>	<b>250,000.0</b>	<b>403,045.3</b>	<b>(190,892.8)</b>	<b>190.0</b>	<b>(153,045.3)</b>	<b>161.2</b>
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	81,000.0	2,708.0	(2,708.0)		78,292.0	3.3
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>509,202.3</b>	<b>230,000.0</b>	<b>2,221,130.5</b>	<b>(1,711,928.2)</b>	<b>436.2</b>	<b>(1,991,130.5)</b>	<b>965.7</b>
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	509,202.3	230,000.0	2,221,130.5	(1,711,928.2)	436.2	(1,991,130.5)	965.7
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-		-	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 388 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор Засгийн газрын авто бааз Улсын төсөвт үйлдвэрийн газрыг Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулж, дүрмийг баталсан байна.

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ нь төрийн байгууллагууд болон бизнесийн байгууллагатай хамтран тээвэрлэлтийн нийтлэг үйлчилгээгээр хангах чиг үүрэгтэй, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажилладаг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Үйлдвэрийн газрын дүрмийн 4.3-т дараах чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр заажээ. Үүнд:

- Төр, засгийн байгууллагад албан тушаалын, дуудлагын, орон нутгийн албан томилолтын зориулалтын автомашинаар шуурхай, соёлтой, аюулгүй, баталгаатай тээвэрлэлтийн үйлчилгээг өндөр түвшинд үзүүлэх;
- Автомашины хэвийн ажиллагааг хангах зорилгоор засвар, үйлчилгээ үзүүлэх;
- Төр, засгийн урилгаар ирсэн зочин төлөөлөгчдөд тээврийн үйлчилгээ үзүүлэх
- Үйлдвэрийн газрын санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, санхүү, хөрөнгө оруулалтын үр ашиг, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн шинэ дэвшилтэт техник, технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бизнесийн болон бусад үйл ажиллагаа.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд их хэмжээний өөрчлөлт ороогүй хэдий ч Зам тээврийн сайдын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/246 дугаар тушаалаар “Авто тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх” тусгай зөвшөөрлийг тус газарт олгож, гэрээ байгуулсан байна.

Тус үйлдвэрийн газар улсын бүртгэлийн гэрчилгээндээ тус чиг үүргийг 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр нэмэлт өөрчлөлтөөр бүртгүүлсэн байна.

Тайлант онд Монгол Улсын Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газраас 2025 оны 02 дугаар удирдамжаар тус ТӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж санхүүгийн тайлагнал, үйл ажиллагаатай холбоотой 7,090.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 7 зөвлөмж өгсөн байна. Илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж үр дүнг гаргаж, хэрэгжилтийг 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 01/295 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус авто баазын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус авто бааз нь Улсын төсөвт үйлдвэрийн газрын үед мөрдөж байсан 2019 онд батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэхгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад орсон өөрчлөлт

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82.9 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,806,837.1	156,159.6	(1,650,677.5)
Авлага	202,645.2	387,798.4	185,153.3
Бараа материал	75,767.7	105,556.8	29,789.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10,507.3	15,246.9	4,739.6
Үндсэн хөрөнгө	14,245,702.8	15,593,829.5	1,348,126.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>16,341,460.1</b>	<b>16,258,591.2</b>	<b>(82,868.8)</b>
Өр төлбөр	519,202.3	2,221,130.5	1,701,928.2
Эздийн өмчийн дүн	15,822,257.8	14,037,460.7	(1,784,797.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>16,341,460.1</b>	<b>16,258,591.2</b>	<b>(82,868.8)</b>

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 156.2 сая төгрөг болж өмнөх оноос 1,660.7 сая төгрөгөөр буурсан нь нийт 8,433.4 сая төгрөгийн орлого орж, нийт 9,407.8 сая төгрөгийг зарцуулсан нь нөлөөлжээ;
- Тайлант онд авлага дансны үлдэгдэл 403.0 сая төгрөг болж, өмнөх оноос 189.9 сая төгрөгөөр өссөн нь нийт 12,368.2 сая төгрөгийн авлага нэмэгдэж, 12,178.3 сая төгрөгийн авлагыг барагдуулсан ба 169.0 сая төгрөгөөр тээврийн үйлчилгээний авлага, 12.0 сая төгрөгөөр ажилчдаас авах авлага, 1.9 сая төгрөгөөр техникийн хяналтын үзлэгийн авлага, 4.8 сая төгрөгөөр гражийн түрээсийн авлага тус тус нэмэгдсэнтэй холбоотой;

Нийт авлагын 47.6 хувь буюу 192.1 сая төгрөгийн авлага 24 сараас дээш насжилттай бөгөөд тус авлагаас Улаанбаатар Такси ХХК-аас авах 80.2 сая төгрөгийн авлага шүүхийн шийдвэр нь гарч төлөгдөх шатандаа байна.

- Урьдчилж төлсөн зардлын үлдэгдэл 15.2 сая төгрөг болж, өмнөх оноос 4.7 сая төгрөгөөр өссөн нь Сод Монгол болон Петростарын шатахууны картын үлдэгдэл байна;
- Бараа материалын үлдэгдэл 105.6 сая төгрөг болж, өмнөх оноос 29.8 сая төгрөгөөр өссөн нь 1,752.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 1,705.5 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулан, Үйлдвэрийн газрын захирлын 2025 оны А/20 дугаар тушаалаар 8.3 сая төгрөгийн аж ахуйн материал, 9.3 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг акталж устгасантай холбоотой;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15,593.8 сая төгрөг болж, өмнөх оноос 1,348.1 сая төгрөгөөр өссөн байна. Тухайлбал,

Үндсэн хөрөнгө нэмэгдсэн:

- Барилга байгууламжийн хувьд 50 автомашины гражийн барилгад 225.6 сая төгрөгийн их засварыг хийж, үнэлгээг нэмэгдүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 66, 134, 288, 878 дугаар тогтоолуудаар 309.3 сая төгрөгийн өртөг бүхий 4 тээврийн хэрэгслийг балансаас баланст, ТӨБЗГ-н 2025 оны Д/126 дугаар тогтоолоор “Хүмүүн фильм ТББ”-аас авах Мерседес бенз ML350 маркийн авто машиныг 56.0 сая төгрөгт тооцож, авлага бууруулан баланст бүртгэсэн;
- ТӨБЗГ-ын 2024 оны А-1/1689 дугаар албан бичгээр УИХ-ын Тамгын газрын хөрөнгө оруулалтаар, 2,719.5 сая төгрөгийн өртөг бүхий 17 ширхэг тээврийн хэрэгслийг худалдан авах ажиллагааны хуулийн дагуу тендер шалгаруулалтыг хийн худалдан авсан;
- ТӨБЗГ-ын 2024 оны 717 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад батлагдсаны дагуу 344.7 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 12.5 сая төгрөгийн тавилга, эд хогшлыг худалдан авсан байна.

Үндсэн хөрөнгө хасагдсан:

- ТӨБЗГ-ын 2025 оны 106, 134, 137, 228, 478, 495, 687, 672, 759, дугаар тогтоолуудаар балансаас баланст 1,796.2 сая төгрөгийн өртөг бүхий 16 ширхэг тээврийн хэрэгслийг төрийн өмчийн харьяа байгууллагуудад шилжүүлсэн;
- ТӨБЗГ-ын 2025 оны 514 дүгээр тогтоолоор 11.3 сая төгрөгийн 14 нэр төрлийн тавилга эд хөгшлийг худалдан борлуулах тогтоол гарч тайлант онд 6.1 сая төгрөгийн 9 нэр төрлийн тавилга, эд хогшлыг худалдан борлуулсан байна.
- ТӨБЗГ-ын 2025 оны 472 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 68.9 сая төгрөгийн 2 тээврийн хэрэгслийг 22.0 сая төгрөгөөр дахин үнэлснээс үндсэн хөрөнгө 46.8 сая төгрөгөөр буурсан байна.
- Өр төлбөрийн үлдэгдэл 2,221.1 сая төгрөг болж өмнөх оноос 1,701.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь шатахуунд 50.0 сая төгрөг, тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгслийн үнийн төлбөрт 515.2 сая төгрөг, татварт 217.4 сая төгрөг, НДШ-д 198.2 сая төгрөг, 2024 оны ноогдол ашгийн өглөг 713.9 сая төгрөг, баталгаа барьцааны өглөг 26.8 сая төгрөг, харуул хамгаалалтад 10.0 сая төгрөгийг төлөөгөйтэй холбоотой байна.

- Эздийн өмчийн тухайд өмнөх оноос 14,037.5 сая төгрөг болж өмнөх оноос 1,784.8 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 1,092.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаас шалтгаалсан байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 717 дугаар тогтоолоор “2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 10,534.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 10,522.4 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,485.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 8,314.9 сая төгрөгийн орлого оруулж, 9,407.8 сая төгрөгийг зарцуулан, 1,092.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 8,314.9 төгрөг болж төлөвлөснөөс 2,219.2 сая төгрөгөөр буюу 21.1 хувиар тасарсан нь түрээсийн орлого 94.2 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын орлого 481.5 сая төгрөгөөр тус тус давж биелсэн ба тээврийн орлого 1,890.5 сая төгрөгөөр, тээврийн хэрэгслийн үзлэгийн орлого 899.1 сая төгрөгөөр, бусад орлого 5.2 сая төгрөгөөр тус тус тасарсантай холбоотой байна. Тухайлбал,

- Тээврийн орлого 1,890.5 сая төгрөгөөр тасарсан нь Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлснээр үйлчилгээний ажлын гүйцэтгэл багассан, мөн тээврийн хэрэгслийн насжилт өндөрсөж тээвэрлэлтийн стандартад нийцэхгүй болсноос шалтгаалсан;
- Оношилгооны орлого 899.1 сая төгрөгөөр тасарсан нь үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хойшлогдож 11 дүгээр сард гарсантай холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 9,407.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 90.0 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар дутуу байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээнд нийт 6 нэр төрлийн 1,485.5 сая төгрөг батлагдсанаас 5 нэр төрлийн ажилд 426.4 сая төгрөг буюу 28.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Авто машины парк шинэчлэлтэд 360.0 сая төгрөг төлөвлөснөөс төлөвлөсөн орлого бүрдээгүйгээс төсөв дутагдаж хэрэгжээгүй;
- Техникийн хяналт, үзлэгийн багаж тоног төхөөрөмж худалдан авахад 900.0 сая төгрөг төлөвлөснөөс 393.3 сая төгрөг зарцуулж, 506.7 сая төгрөг;
- Халуун хүйтэн усны шугам болон Конторын дотор баруун зүүн салбар шугам, Хүйтэн усны төв шугам солиход 200.0 сая төгрөг төлөвлөснөөс 20.0 сая төгрөгийг зарцуулж, 180.0 сая төгрөг;
- Компьютер тоног төхөөрөмж худалдан авахад 7.0 сая төгрөг төлөвлөснөөс 0.6 сая төгрөгийг зарцуулж, 6.4 сая төгрөг;
- Программ хангамж болон бусад хөрөнгө худалдан авахад 6.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч хэрэгжээгүйгээс нийт 1,059.1 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Тавилга эд хогшил худалдан авахад 12.5 сая төгрөг төлөвлөснийг бүрэн зарцуулсан байна.

Тайлант онд татвар төлөхийн өмнөх ашгийг 11.7 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч 1,092.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь орлого 2,219.2 сая төгрөгөөр тасарч, сэлбэгийн зардал 112.4 сая төгрөгөөр, хөдлөх хөрөнгөтэй холбоотой бичиг хэргийн зардал 247.4 сая төгрөгөөр, элэгдлийн зардал 122.9 сая төгрөгөөр, гэрэл цахилгааны төлбөр 16.0 сая төгрөгөөр, цэвэр бохир усны зардал 7.9 сая төгрөгөөр, зар сурталчилгааны зардал 4.4 сая төгрөгөөр төлөвлөснөөс илүү гүйцэтгэлтэй гарсан ба данснаас хасагдсан хөрөнгийн элэгдлийн зардал 657.0 сая төгрөг зэргээс шалтгаалсан байна.

ТӨБЗГ-ын 2024 оны 717 дугаар тогтоолоор тайлант онд түрээсийн орлогоос 170.4 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан ба ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлд “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газар нь аж ахуйн тооцоонд шилжин ажиллаж эхэлснээс хойш төрийн байгууллагад үзүүлсэн тээврийн үйлчилгээнд алдагдалтай байгааг харгалзан төрийн өөрийн өмчийн түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэлгүй бүхэлд нь тус үйлдвэрийн газарт үлдээх нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨБЗГ-аас Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлахдаа орлогыг нэр төрлөөр баталдаг боловч, зардлыг нэр төрлөөр батлаагүй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- Программ хангамжийн талаарх судалгаа авахад тус авто бааз нь 2023 онд “Ординат” ХХК-ийн 10.8 сая төгрөгийн өртөгтэй нягтлан бодох бүртгэлийн “Unicus” программ хангамжийг ашиглаж байгаа бөгөөд тайлант онд 1.8 сая төгрөгийн засвар үйлчилгээний төлбөр төлсөн байна.
- Тайлант онд тус авто баазын орон тоог 158-оор баталж, 5,091.1 сая төгрөгийн цалингийн зардлыг төлөвлөсөн ба гүйцэтгэлээр удирдах 1, дунд шатны удирдах албан тушаалтан 5, гүйцэтгэх 124 нийт 130 албан хаагчтайгаар 3,785.7 сая төгрөгийн цалингийн зардал зарцуулжээ. Тус авто бааз тус ТӨБЗГ-ын А1/1192 дугаар албан бичгийг үндэслэн тэтгэвэрт гарсан ажилчдын орон тоог царцаан ажилласан байна.
- Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын захирлын 2023 оны А/22 дугаар тушаалаар ажилтнуудад ажлын нэг өдрийн хоолны зардалд 12.0 мянга, унааны зардалд 2.0 мянган төгрөгийг олгож байна. Тайлант онд нийт 320.1 сая төгрөгийн хоолны хөнгөлөлт, 53.3 сая төгрөгийн унааны хөнгөлөлт, нийт 373.4 сая төгрөгийг олгожээ.
- Гадаад албан томилолтод 47.0 сая төгрөгийн 7 арга хэмжээ төлөвлөсөн боловч гүйцэтгэл гаргаагүй байна.
- Автотээврийн 100 жилийн ой болон Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 90 жилийн ойн баярын хурлыг Төрийн ордонд зохион байгуулахад 48.1 сая төгрөгийг төлөвлөж, 79.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулахаар төрийн хэмнэлтийн тухай хууль, худалдан авах ажиллагаа, баазын захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, ажилтан алба хаагчдад олгох тэтгэмж, урамшуулалтай холбоотой өгсөн аудитын шийдвэрүүдийг тусгасан болно.

Аудитыг “Платинум прогресс аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор Н.Номин-Эрдэнэ, Э.Туяасайхан нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг захирал Ж.Баяртуул, үе шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Лхагвацэнд, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, Газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01/41 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 11,432.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 114.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус үйлдвэрийн газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан, дотоод тээврийн зардлыг хэмнэсэн, хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлсэн эсэхийг хамруулан шалгахад мэдээлэх үүрэгтэй 25 тайлангийн 155 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод, бүрэн байршуулсан ба 2 төрлийн мэдээллийн хуулийн хугацаа болоогүй байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ нь жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн хэдий ч бусад хууль тогтоомжтой холбоотой дараах зөрчлүүд байна. Үүнд:

1. ТӨБЗГ-ын 2024 оны 735 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин дэх орлогын төлөвлөгөөг 2,219.2 сая төгрөгөөр биелүүлээгүй байна.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" гэснийг зөрчиж, бодитой төлөвлөж хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: ТӨААТҮГ тухайн оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин дэх орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тус баазын удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан ажилтан шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсноос уг ажилтанд олгосон цалин 7.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй 3 жил болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт авлага барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын шилэн дансанд

байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн ТӨБЗГ-ын тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитын хугацаанд Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, гадаад, дотоод орчин, хяналтын талаар ойлголт олж, аудитын урьдчилсан судалгааны болон төлөвлөлтийн үе шатны ажлуудыг гүйцэтгэж, төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 17.6 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 32.2 сая төгрөгийн 5 албан шаардлага, 7 зөвлөмж өгснийг 92.9 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	4	17,600.0	4	17,600.0	100.0
Албан шаардлага	5	32,211.8	5	28,668.4	89.0
Зөвлөмж	7	-	7	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>16</b>	<b>49,811.8</b>	<b>16</b>	<b>46,268.4</b>	<b>92.9</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.5. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт бүртгэлтэй 7 тээврийн хэрэгсэлүүдийн урсгал засвар, шатахууны зардалд тус ТӨААТҮГ-аас хөрөнгө зарцуулж буй асуудлыг аудитын өгсөн албан шаардлагын дагуу удаа дараа албан бичиг хүргүүлсэн боловч дэд шатны байгууллага шийдвэрлэж өгөхгүй байгаатай холбоотой аудитын шийдвэрийн хэрэгжилт хангагдахгүй байгаа асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 178.1 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 9.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 121.1 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 47.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн нийт 164.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 ТӨЛБӨРИЙН АКТ

1. Тайлант онд ажиллагсдын илүү цагийн хөлсийг сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлж 8.4 сая төгрөг, илүү цагийн тооцооны хуудасгүй, мөн тооцооны хуудсаар баталгаажсан илүү цагийн дүнгээс өөр дүнгээр бодсон 1.3 сая төгрөг, нийт 9.7 сая төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь тус байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 20 дугаар зүйлийн 20.4.8-д "Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолд заасны дагуу илүү цагийг тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэхгүй", мөн МУ-ын Сангийн сайдын 2008 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн В-58/8353 тоот албан бичиг-т " ... жолооч нарын илүү цагийг сард 40 цагаас илүүгүй байхаар тооцсон", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж тус тус заасныг зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна..

Шийдвэрлэсэн нь: Ажиллагсдад илүү дүнгээр тооцож олгосон 9.7 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 АЛБАН ШААРДЛАГА

1. Тайлант онд өргөдлийн дагуу 14 ажилтанд бусад зардлын данснаас 44.0 сая төгрөгийн зээл олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан бөгөөд оны эцэст 12.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" гэснийг зөрчиж зориулалтын бус үйл ажиллагаанд зарцуулж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтны өргөдлөөр мөнгөн зээл олгож авлага үүсгэж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Зөрчил гаргасан жолооч нарын 25 удаагийн торгуульд 6.8 сая төгрөгийг төлж зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэснийг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жолоочийн хариуцлагын торгуулийг компанийн төсвөөс төлөхийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант онд "автомашин дугуй худалдан авах" нээлттэй тендер зарлаж 2 нийлүүлэгчээс 103.1 сая төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 44.9 сая төгрөгийн дугуй худалдан авсан ба тендерт шалгараагүй компаниудаас нийт 70.3 сая төгрөгөөр 83 ширхэг дугуй худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1-д "худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах", 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх;" гэж заасныг зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарч гэрээг байгуулаагүй нийлүүлэгчээс өндөр үнийн дүнгээр худалдан авалт хийхийг таслан зогсоож зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал:

1. Илрүүлэлт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 184 дүгээр тогтоолоор олгосон 15.0 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг бусад зардлаас олгож цалингийн суутган тооцоолол хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэснийг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үр дүнгийн урамшууллыг цалингийн сангаас олгож зохих суутган тооцооллуудыг хийж байх.

2. Илрүүлэлт: Тайлант онд 32.3 сая төгрөгийн үйлчилгээний төлбөрийг барагдуулаагүй авлага үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах; 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант оны үйлчилгээний авлагыг тухай бүр барагдуулж, авлага төлбөрийн тооцоог хянаж байх;

Дээрх аудитын шийдвэрийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс												
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
1	Тайлант онд өргөдлийн дагуу 14 ажилтанд бусад зардлын данснаас 44.0 сая төгрөгийн зээл олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан бөгөөд оны эцэст 12.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна	1	44,000.0			1	44,000.0									
2	Зөрчил гаргасан жолооч нарын 25 удаагийн торгуульд 6.8 сая төгрөгийг төлж зардлаар тайлагнасан байна.	1	6,841.3			1	6,841.30									
3	Тайлант оны эцэст 4 ААНБ, 1 иргэнтэй холбоотой 32.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	32,261.6					1	32,261.6							
4	Тайлант онд ажилтнуудад илүү цагийн хөлсийг тооцож олгохдоо нийт 13.6 сая төгрөгийг илүү олгосон байна. Үүнд: 1. Сарын ажлын цагийн 10 хувиас хэтэрсэн 8.4 сая төгрөг, 2. Жолоочийн илүү цагийг тооцохдоо 40 цагаас хэтэрсэнд 3.9 сая төгрөг олгосон, 3. Тооцооны хуудсаар баталгаажсан дүнгээс илүү цагийн хөлсийг 1.3 сая төгрөгөөр илүү олгосон.	1	9,742.8	1	9,742.8											

“Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

5	ТӨБЗГ-ын 2025 оны 184 дүгээр тогтоолоор олгосон 15.0 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг бусад зардлаас олгож цалингийн суутган тооцоолол хийгээгүй байна.	1	15,000.0				1	15,000.00					
6	Тайлант онд "автомашины дугуй худалдан авах" нээлттэй тендер зарлаж 2 нийлүүлэгчээс "Жип ангиллын автомашины зуны дугуй-76, өвлийн дугуй-16, "Седан загварын автомашины зуны дугуй-124, өвлийн дугуй-64, нийт 103.1 сая төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 44.9 сая төгрөгийн дугуй худалдан авсан ба тендерт шалгараагүй компаниудаас өндөр үнээр 83 дугуйг нийт 70.3 сая төгрөгөөр худалдан авч, 12.1 сая төгрөгөөр төсөвт өртгийг хэтрүүлсэн байна.	1	70,276.0		1	70,276.0							
<b>Дүн</b>		<b>6</b>	<b>178,121.8</b>	<b>1</b>	<b>9,742.8</b>	<b>3</b>	<b>121,117.3</b>	<b>2</b>	<b>47,261.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>									
1	ТӨБЗГ-ын 2024 оны 735 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин дэх орлогын төлөвлөгөөг 2,219.2 сая төгрөгөөр биелүүлээгүй байна.	1	2,219,168.8			1	2,219,168.8		
2	Тус байгууллагын удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан ажилтан шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсноос уг ажилтанд нөхөн олгосон цалин 7.8 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй 3 жил болсон байна.	1	7,821.6			1	7,821.6		
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>2,226,990.4</b>			<b>2</b>	<b>2,226,990.4</b>		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 751/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/31/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд “автомашин дугуй худалдан авах” нээлттэй тендер зарлаж 2 нийлүүлэгчээс нийт 103,112,000.00 (нэг зуун гурван сая нэг зуун арван хоёр мянга) төгрөгийн худалдан авалтын гэрээ байгуулж, гүйцэтгэлээр нийт 44,947,000.00 (дөчин дөрвөн сая есөн зуун дөчин долоон мянга) төгрөгийн дугуй худалдан авсан ба гэрээ байгуулаагүй компаниудаас нийт 70,276,000.00 (далан сая хоёр зуун далан зургаан мянга) төгрөгөөр 83 ширхэг дугуй худалдан авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах.”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.1-д “худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах”, 48.2.7-д “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх” гэж заасныг зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Тендерт шалгараагүй, гэрээ байгуулаагүй нийлүүлэгчээс худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлж, арга хэмжээ авч ажиллахыг “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын захирал (Г.Чинзориг), ерөнхий нягтлан бодогч (Б.Солонго) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Ж.БАЯРТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-262230

Z:\Alban Shaardlaga\2026\31\SA-STA-TH.docx

1526180962



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 750/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/31/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд өргөдөл гаргасан 14 ажилтанд бусад зардлын данснаас 44,000,000.00 (дөчин дөрвөн сая) төгрөгийн зээл олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан бөгөөд оны эцэст 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгийн авлага үүсгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах,” гэснийг зөрчин зориулалтын бус үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэл хангагдаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагач эгтээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төсвийг зориулалт бус зарцуулан ажилчдад зээл олгож, авлага үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, авлагыг барагдуулж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, төрийн өмчийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулахыг “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын захирал (Г.Чинзориг), ерөнхий нягтлан бодогч (Б.Солонго) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Ж.БАЯРТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\4\San\Shardlaga\2026\01\6-54G-38.Docx

1526180976



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 752/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/31/НА-СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 735 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин” дэх орлогын төлөвлөгөөг 2,219,168,797.91 (хоёр тэрбум хоёр зуун арван есөн сая нэг зуун жаран найман мянга долоон зуун ерэн долоон төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгөөр биелүүлээгүй байна.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэснийг зөрчиж, бодитой төлөвлөж хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг батлуулахдаа орлогын тооцооллыг үндэслэлтэй төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, төрийн өмчийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөж, захиран зарцуулж байхыг “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын захирал (Г.Чинзориг), ерөнхий нягтлан бодогч (Б.Солонго) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Ж.БАЯРТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\4\for\Shaardlaga\2026\316\SAГ-26.docx

1526190960



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 749/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/31/НА - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Удирдлагын буруу шийдвэрээр ажлаас халагдсан ажилтан шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орсноос уг ажилтанд олгосон цалин 7,821,616.98 (долоон сая найман зуун хорин нэгэн мянга зургаан зуун арван зургаан төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн авлагыг барагдуулаагүй, ямар нэгэн арга хэмжээ аваагүй 3 жил болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, гэж заасныг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Буруу шийдвэр гаргасан “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын захирал Г.Чинзоригор хохирлыг төлүүлэх арга хэмжээг авч зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ч.Бат-Эрдэнэ)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Ж.БАЯРТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Э: /libar/Shaardlaga/2026/016 SHG-M.Doc

1526180978



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 753/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/31/НА - СТА - ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу 2022 онд төрийн өмчийн байгууллагуудаас татан төвлөрүүлэлтээр ирсэн тээврийн хэрэгслүүдийн татвар, торгуулийг төлүүлээгүй шилжилт хөдөлгөөн хийснээс татварын байгууллагаас шаардсан 25 удаагийн торгуульд нийт 6,841,300.00 (зургаан сая найман зуун дөчин нэгэн мянга гурван зуу) төгрөгийг төлж зөрдлөөр тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, гэснийг зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэл хангагдаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Жолоочийн хариуцлагатай холбоотой торгууль хураамжийг төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын төсвөөс гаргахыг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллахыг “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын захирал Г.Чинзориг, ерөнхий нягтлан бодогч Б.Солонго нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

*Г. Чинзориг*  
*Б. Солонго*

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Ж.БАЯРТУУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, “Бага тойруу”-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Мөн Шаардлага\2026\31\САГ-36.Docx

1526180964



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 162/АДИСО182

Улаанбаатар хот

САГ-2026/31/НА - СТА - ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ажилчдын илүү цагийн хөлсийг сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлж 8,397,321.52 (найман сая гурван зуун ерэн долоон мянга гурван зуун хорин нэгэн төгрөг тавин хоёр мөнгө) төгрөг, илүү цагийн тооцооны хуудасгүй болон тооцооны хуудсаар баталгаажсан дүнгээс илүү дүнгээр бодсон 1,345,502.19 (нэг сая гурван зуун дөчин таван мянга таван зуун хоёр төгрөг арван есөн мөнгө) төгрөг, нийт 9,742,823.71 (есөн сая долоон зуун дөчин хоёр мянга найман зуун хорин гурван төгрөг далан нэгэн мөнгө) төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, МУ-ын Сангийн сайдын 2008 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн В-58/8353 тоот албан бичиг-т “... жолооч нарын илүү цагийг сард 40 цагаас илүүгүй байхаар тооцсон”, ТӨААТҮГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 20 дугаар зүйлийн 20.4.8-д “Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолд заасны дагуу илүү цагийг тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэхгүй” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон,” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 31-264230

2-MN-0000016 SAO-21.Docx

152600185

1. Ажилтанд буруу тооцож олгосон илүү цагийн хөлс 9,742,823.71 (есөн сая долоон зуун дөчин хоёр мянга найман зуун хорин гурван төгрөг далан нэгэн мөнгө) төгрөгийг тооцооны нягтлан бодогч (Н.Сайнбаяр)-аар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 1009000000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-ын захирал (Г.Чинзориг), Ерөнхий нягтлан бодогч (Б.Солонго) нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПЛАТИНИУМ ПРОГРЕСС АУДИТ ХХК-ийн  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Ж.БАЯРТУУЛ